

2023

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ

AND ENERGY JSC

AND ENERGY

ЭЙ АМЬДАРЪЯ
Й АМЬДАРЪЯ
Й АМЬДАРЪЯ
Й АМЬДАРЪЯ

ГЭРЭЛТЭЙ АМЬДАРЪЯ

ON

ГЭРЭЛТЭЙ А
ГЭРЭЛТЭЙ А
ГЭРЭЛТЭЙ АМ
ГЭРЭЛТЭЙ АМЬ

AND ENERGY

ТУЗ-ийн удирдлагын мэндчилгээ

Монголын анхны гэрэл цацруулсан баялаг үйлдвэрлэгч Анд-Энерги ХК-ийн Хувьцаа эзэмшигчид та бүхэндээ чин сэтгэлийн халуун мэндчилгээ дэвшүүлье.



Гэрэлтэй амьдаръя эрхэм уриатай Анд-Энерги ХК нь Эрдэнэсийн өлгий Эрдэнэт хотоос гэрэл гэгээ, хөгжил дэвшлийг түгээсээр байна. Манай хамт олон Монгол хүний саруул ухаан, алсын хараагаар дэвшилтэт технологи шингэсэн үйлдвэрлэлийн процессыг удирдаж, үйл ажиллагаагаа тасалдуулалгүй ажилласаар ирлээ.

Лед гэрэл үйлдвэрлэх технологийг эх орондоо нутагшуулж, гэрэл гэдэг бүтээгдэхүүнийг Монгол улсад анхлан үйлдвэрлэж эхэлсэн, анхны гэрлийн лабораторийг байгуулсан, орон нутгаас анхны нээлттэй хувьцаат компани болсон гээд АНХНЫ гэх тодотголтой түүхэнд тодоор бичигдэх ололт амжилт бидэнд бий.

Бид 2023 онд хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг дээдлэх, ногдол ашгийн бодлогыг дэмжих, хувьцааны үнэ цэнийг нэмэгдүүлэх, компанийн засаглал, дэд бүтцийг сайжруулах, худалдан авах ажиллагааны шууд гэрээ байгуулах гарцыг нээх, гадаад харилцааг өргөтгөх, шинэ үйлдвэрлэлийн шугам нэвтрүүлэх судалгаа хийх, эрчим хүч, утааны асуудлын шийдлийг олох гэх мэт олон ажлуудыг хийсэн байна.

Монголын анхны гэрэл үйлдвэрлэгч Анд-Энерги ХК-ийн хамт олон, хувьцаа эзэмшигчид, брокер дилерийн компаниуд, аудитын байгууллагууд, үнэт цаасны биржийн хамт олон, гадаад, дотоод түншүүд, найз нөхөд, хамтран ажилласан албан байгууллага, хувь хүмүүс, компани аж ахуйн нэгжүүд, эрхэм хүндэт худалдан авагчид, хэрэглэгчид та бүхэндээ баярласан талархсанаа илэрхийлж гэрлийн үйлдвэр байгуулагдсаны түүхт 10 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье.

Та бүхэнд амжилт, сайн сайхныг хүсье.

ТУЗ-ийн дарга

Ц.Барс



ГЭРЭЛТЭЙ АМЬДАРЪЯ

Хурлын тов:
2024 оны 4 сарын 27-ны өдрийн 14:00 цагт

Хурал болох газар:
АНД ЭНЕРГИ ХК үйлдвэрийн байр

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр:
2024 оны 4 сарын 5-ний өдөр 18:00 цаг

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1.“Анд Энерги” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

2.“Анд Энерги” ХК-ийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай

SCAN ME

FACEBOOK PAGE

НАМАЙГ УНШУУЛ

1 Агуулга

1. Компанийн танилцуулга
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах тухай ТУЗ-ийн тогтоол
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар танилцуулах баримт бичгийн жагсаалт
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төсөл
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудас

2 Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой баримт бичигүүд

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;
2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт;
3. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудасны загвар;
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг;
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төсөл;
6. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга;
7. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай тогтоол



КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

КОМПАНИЙН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Компанийн үндсэн үйл ажиллагааг дараах 4 төрөлд хуваан авч үзнэ.

- ► LED гэрэл, гэрэлтүүлгийн үйлдвэрлэл
- ► Цахилгаан тоног төхөөрөмжийн угсралт, засвар үйлчилгээ
- ► Үйлдвэрлэлийн автоматжуулалт
- ► Худалдаа

Үнэт зүйл

Зөв засаглал

Бид хэрэглэгч бүрийн хүсэн хүлээдэг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг, ажилтан бүр өсөж дэвждэг, аз жаргалтай ажлын орчин бий болгосон, хувьцаа эзэмшигчид ашиг хүртэх, ил тод, үнэнч шударга, зөв засаглалтай жишиг байгууллага мөн.

Шинэ санаачилга, бүтээлч байдал

Бид үргэлж технологийн хөгжил дэвшил, асуудлыг шийдвэрлэх бүтээлч шийдэл бүхий санал санаачилгыг дэмжин бүтээгдэхүүн хөгжүүлэлтдээ нэвтрүүлэн ажилладаг.

Эрдэм мэдлэг

Бид мэдлэгийг хязгааргүйд тооцон цаг үргэлж суралцан, өөрсдийгөө болон баг хамт олноо хөгжүүлж, ухаалаг зөв сэтгэлгээтэй үнэн шударга замналыг бий болгон ажилладаг.

Хамтын хүч

Бид эерэг хандлагатай байж, хамтын хүчийг дээдлэгч хамт олныг бүрдүүлж, бүтээмж өндөртэй ажилладаг.

Үзэл баримтлал

- ►Хууль, дүрмийг чандлан сахиулан ажиллах
- ►Техник, технологийн хөгжилтэй хөл нийлүүлэн, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг явуулах
- ►Хамтын хүч, бүтээлч сэтгэлгээ, шинэ санал санаачилгыг дэмжин ажиллах
- ►Эрүүл аюулгүй орчинг бүрдүүлж, ажилчдыг өсөн дэвших бодлого баримтлан ажиллах
- ►Харилцагч, хэрэглэгчийг инээмсэглэлээр угтаж, итгэлээр үдэх

“АНД-ЭНЕРГИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 3 сарын 16 өдөр | Дугаар 24/07 | Орхон аймаг

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.4 дэх заалтууд, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх заалтууд, 64 дүгээр зүйлийн 64.1 дах заалт, 76 дугаар зүйлийн 76.1.2, дахь заалт, Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. “Анд Энерги” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 4 сарын 27-ны өдрийн Бямба гарагийн 14:00 цагт Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг, Баян зам 3-4,6 тоотод байрлах үйлдвэрийн байранд цахим хэлбэрээр хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулж байгаатай холбогдуулан ***MI SURVEY*** программыг цахим бүртгэл, санал хураалт явуулахад ашиглахыг зөвшөөрсүгэй.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:

   3.1 Танилцуулах асуудал:

   1. ТУЗ-ийн 2023 оны ажлын тайлангийн танилцуулга;
   2. “Анд Энерги” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга;
   3. Си Пи Ти Эй Аудит ХХК-ийн 2023 оны аудитлагдсан тайлангийн дүгнэлтийн танилцуулга;
   4. “Анд Энерги” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах тухай тогтоолын танилцуулга

   3.2 Хэлэлцэх асуудал:

   1. “Анд Энерги” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
   2. “Анд Энерги” ХК-ийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай;

4. Хувьцаа эзэмшигчийн хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-н нэгдүгээр хавсралтаар батлагдсан загварын дагуу гаргаж холбогдох баримтын хамт 2024 оны 3 дугаар сарын 19-ний өдөрт багтаан Санхүүгийн зохицуулах хороо болон Улаанбаатар үнэт цаасны биржид хүргүүлэхээр тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Хавсралт №1-ээр баталж, 2024 оны 3 дугаар сарын 21-ний өдөр Улаанбаатар үнэт цаасны бирж болон өөрийн цахим хуудас, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сониноор дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, зарыг давтан 2024 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр анх мэдээлсний дагуу олон нийтэд хурлын зарыг дахин хүргэхээр тогтоосугай.

6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 18:00 цаг байхаар тогтоосугай.

7. Танилцах баримт бичгийн жагсаалт, Ээлжит хурлын дэгийг Хавсралт №2-оор баталж, 2024 оны 3 дугаар сарын 26-ны өдөрт багтаан хувьцаа эзэмшигчид болон тэдгээрт үйлчилж буй брокер, дилерийн компаниудад цахим хэлбэрээр хүргүүлэх, мөн тухайн өдрөөс эхлэн 09:00-17:00 цагийн хооронд Анд-Энерги ХК-ийн үйлдвэрийн байранд ирж танилцах болон www.andenergy.mn цахим хуудас, www.facebook.com/AndEnergy facebook хуудсаар орж хурлын материалыг электрон хэлбэрээр татан авч танилцах боломжийг бүрдүүлсүгэй.

8. Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах "Саналын хуудас"-ын агуулгыг Хавсралт №3, Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тогтоолын төслийг Хавсралт №4, Компанийн 2023 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тогтоолын төслийг Хавсралт №5, ТУЗ-ийн гишүүдийг томилох тухай тогтоолын төслийг Хавсралт №6-аар тус тус баталсугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах дарга болон зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Хурлын дарга:

ТУЗ-ийн дарга - Т.Барс

Комиссын дарга:

Гүйцэтгэх захирал - Ц.Гүррагчаа

Комиссын гишүүд:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга - Б.Тогос-Эрдэнэ;
Санхүүгийн менежер - П.Бямбасүрэн;
Маркетинг, борлуулалт хариуцсан менежер - М.Эрдэнэцэцэг;
Хүний нөөцийн менежер - Э.Ариунсайхан;
Үйлдвэрлэлийн менежер - Э.Нямгэрэл

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Дэлгүүрийн менежер - М.Дэлгэрмаа

Комиссын гишүүд:

Тооцооны нягтлан бодогч – С.Алтанцэцэг;
Маркетингийн менежер - Т.Цогтбаяр;

11. Хувьцаа эзэмшигчдийг хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулж байгаатай холбогдуулан холбогдох дүрэм журамд нийцүүлэн ажиллах, хувьцаа эзэмшигчдийг хурлын материалтай танилцах нөхцөл, боломжийг бүрдүүлж, хуралд бэлтгэх, хурал зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллахыг хурлын дарга Т.Барс, зохион байгуулах комиссийн дарга Ц.Гүррагчаа нарт тус тус даалгасугай.

12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулахтай холбоотой зардлыг компаниас гаргахыг хурлын даргад зөвшөөрсүгэй.

ТУЗ-ИЙН ДАРГА Т.БАРС

“АНД-ЭНЕРГИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

Хурал хуралдах огноо: 2024 оны 4 сарын 27-ны өдрийн 14:00 цагт
Хурлын үргэлжлэх хугацаа: 2 цаг 05 минут

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцах эзэн
1	Хурлын ирцийг бүртгэх	10 минут	Зохион байгуулах комисс
2	Хурлын ирцийг мэдээлэх	5 минут	Тооллогын комисс
3	Хурлын дарга хурлыг нээх	5 минут	Хурлын дарга Т.Барс
4	Хурлын дэг болон хэлэлцэх асуудлуудыг танилцуулах	5 минут	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Тогос-Эрдэнэ
5	ТУЗ-ийн 2023 оны ажлын тайлан танилцуулах	5 минут	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Тогос-Эрдэнэ
6	Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн товч тайланг танилцуулах	15 минут	Гүйцэтгэх захирал Ц.Гүррагчаа
7	Си Пи Ти Эй Аудит ХХК-ийн 2023 оны аудитлаглсан тайлангийн дүгнэлтийг танилцуулах	5 минут	ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо
8	Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулах	5 минут	ТУЗ-ийн дарга Т.Барс
9	2022 оны ногдол ашиг хуваарилалтын тайланг танилцуулах	5 минут	ТУЗ-ийн дарга Т.Барс
10	Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоол шийдвэрийг танилцуулах	5 минут	ТУЗ-ийн дарга Т.Барс
11	ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга	15 минут	Нэр дэвшүүлэх хороо
12	Асуулт хариулт	15 минут	Зохион байгуулах комисс
13	Хурлын завсарлага, санал тоолох	15 минут	Тооллогын комисс, Зохион байгуулах комисс
14	Санал хураалтын дүнг хуралд оролцогчдод танилцуулах /ХЭХурлын тогтоол/	10 минут	Тооллогын комисс, Хурлын дарга Т.Барс
15	Хурлыг хаах	5 минут	Хурлын дарга Т.Барс

Жич: *Шаардлагатай бол хурлын хугацааг сунгаж болно.*

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл
1	Компанийн ногдол ашиг хуваарилах тухай гаргасан ТУЗ-ийн 24/01 тоот тогтоол шийдвэр
2	“Анд-Энерги” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн 2024 оны 3 сарын 16-ны өдрийн 24/07 тоот тогтоол
3	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдэл
4	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар
5	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг
6	Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудасны загвар
7	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төсөл
8	Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан
9	Компанийн 2023 оны санхүүгийн тайлан, хөндлөнгийн аудитын дүгнэлт
10	Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлт
11	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга

АНД-ЭНЕРГИ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: ..... *овогтой* .....

Регистрийн дугаар: .....

Хувьцаа эзэмшигчдийн хурал: .....

Санал өгөх хувьцааны тоо: .....

Үнэт цаасны компанийн нэр: .....

Анд-Энерги ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 сарын 27-ны өдрийн 14:00 цагт Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг, Баян зам 3-4,6 тоотод байрлах "Анд-Энерги" ХК-ийн өөрийн байранд

Цахимаар

№	Хэлэлцэх асуудлууд	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайланд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах эсэх	☐	☐	☐
2	Компанийн 2023 оны санхүүгийн тайланд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах эсэх	☐	☐	☐

Санал өгсөн түүх

IP хаяг	*Хөтөч*	*Хост*	*Огноо*
1			

2024 оны 4 сарын 27-ны өдөр

АНД-ЭНЕРГИ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: ..... *овогтой* .....
Регистрийн дугаар: .....
Хувьцаа эзэмшигчдийн хурал: .....
Санал өгөх хувьцааны тоо .....
Үнэт цаасны компанийн нэр: .....
Кумулятив саналын тоо: .....
ТУЗ-ийн гишүүнийг сонгоход хэрэглэх санал хураах арга: Кумулятив

Анд-Энерги ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 сарын 27-ны өдрийн 14:00 цагт Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг, Баян зам 3-4,6 тоотод байрлах "Анд-Энерги" ХК-ийн өөрийн байранд

№	***ТУЗ-д нэр дэвшигчдийн нэрс***	
	Ердийн гишүүд	Таны ердийн гишүүнд өгөх кумулятив саналын тоо: .....
1		
2		
3		
4		
5		
	Хараат бус гишүүд	Таны хараат бус гишүүнд өгөх кумулятив саналын тоо: .....
1		
2		
3		
4		
5		
Өгөх ёстой кумулятив саналын тооны нийлбэр дүн:		

Санамж: *ТУЗ-ийн гишүүдийг шинээр сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана.*
*Жишээ нь: та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байхад үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон тохиолдолд Хувьцаа эзэмшигч эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй (100*9 гишүүн=900) болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн энгийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно гэдгийг анхаарна уу.*

Санал өгсөн түүх

IP хаяг	***Хөтөч***	***Хост***	***Огноо***
1			

2024 оны 4 сарын 27-ны өдөр

[Төсөл]

“АНД-ЭНЕРГИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 4 сарын 27 өдөр | Дугаар 01 | Орхон аймаг

Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 2024 оны 4 сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Анд-Энерги” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА Т.БАРС

[Төсөл]

“АНД-ЭНЕРГИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 4 сарын 27 өдөр Дугаар 02 Орхон аймаг

Компанийн 2023 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 2024 оны 4 сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Анд-Энерги” ХК-ийн 2023 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА Т.БАРС

[Төсөл]

„АНД-ЭНЕРГИ“ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 4 сарын 27 өдөр | Дугаар 03 | Орхон аймаг

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 2024 оны 4 сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Анд-Энерги ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдэд
   1. ..... овогтой .....
   2. ..... овогтой .....
   3. ..... овогтой .....
   4. ..... овогтой .....
   5. ..... овогтой .....
   6. ..... овогтой .....

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүдэд

   1. ..... овогтой .....
   2. ..... овогтой .....
   3. ..... овогтой .....
   4. ..... овогтой .....
   5. ..... овогтой .....
   6. ..... овогтой ..... нарыг

2024 оны 4 сарын 27-ны өдрөөс эхлэн 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл 2 жилийн хугацаагаар **сонгосугай.**

ХУРЛЫН ДАРГА Т.БАРС

“АНД-ЭНЕРГИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 2 сарын 19 өдөр | Дугаар 24/01 | Орхон аймаг

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.5 дахь заалтууд, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, 2024 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Анд-Энерги ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. “Анд-Энерги” ХК-ийн нийт хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд 90 мөнгө буюу нийт 70,263,682.2 төгрөг (далан сая хоёр зуун жаран гурван мянга зургаан зуун наян хоёр төгрөг хорин мөнгө)-ний ногдол ашгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тасалбар болгон тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгаас хувь хүний болон хуулийн этгээдийн хувьд аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар дамжуулан Хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар ногдол ашиг олгох сүүлийн өдрийг 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөр тогтсугай.
4. Энэхүү тогтоолыг Улаанбаатар үнэт цаасны биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Б.Тогос-Эрдэнэ/-д даалгасугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Д.Мөнхбат/-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА Т.БАРС

“АНД-ЭНЕРГИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 3 сарын 16 өдөр | Дугаар 24/05 | Орхон аймаг

Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайланд дүгнэлт өгөх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, 2024 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Анд-Энерги” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны тайланг “Хангалттай” хэмээн дүгнэсүгэй.
2. Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал Ц.Гүррагчаад үүрэг болгосугай.
3. “Анд-Энерги” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг өөртөө үлдээсүгэй.

ТУЗ-ИЙН ДАРГА Т.БАРС

“АНД-ЭНЕРГИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 3 сарын 16 өдөр | Дугаар 24/06 | Орхон аймаг

Компанийн 2023 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2.6.12 дахь заалт, 2024 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн 2023 оны санхүүгийн тайланг “Хангалтгүй” хэмээн дүгнэсүгэй.
2. Төлөөлөн удирдах зөвлөлөөс санхүүгийн тайланг Хангалтгүй гэж дүгнэсэнтэй холбогдуулан Гүйцэтгэх захирал болон Гүйцэтгэх удирдлагын багт арга хэмжээ авсугай.
3. 2023 оны санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж танилцуулахыг Аудитын хороонд даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА Т.БАРС



БИЗНЕСИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА

1



Манай бүтээгдэхүүн Цахилгааны хэрэглээ болон ашиглалтын зардлыг бууруулна.

2



Бид гэрэлтүүлэг болон автоматжуулалтыг цогцоор нь шийдвэрлэнэ.

3



Манай бүтээгдэхүүн Аюулгүй ажиллагааны эрсдэлийг бууруулна.

4



Буух эзэн буцах хаягтай.

1



Манай бүтээгдэхүүнүүд нь “Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн” ангилалд багтаж хэрэглэгч харилцагч нар маань хүссэн бүтээгдэхүүнээ Хаан банк, Хас банкны ногоон зээлийн санхүүжилтээр авах боломжтой боллоо.

2



TrendForce-ийн "2021 оны дэлхийн гэрэлтүүлгийн LED ба LED гэрэлтүүлгийн зах зээлийн төлөв байдал-2021" тайланд дурдсанаар, LED ерөнхий гэрэлтүүлгийн зах зээлд иж бүрэн гэрэлтүүлгийн эрэлт хэрэгцээ нэмэгдэж, LED ерөнхий гэрэлтүүлэг, цэцэрлэгжүүлэлтийн буюу ургамлын гэрэлтүүлэг, ухаалаг гэрэлтүүлгүүдөсөн нэмэгдсээр байна.

3



Төмөр замын вагоны гэрлийн шийдлийг гаргаж эхний ээлжийн бүтээгдэхүүнийг нийлүүлэв.

4



Ургамлын гэрлийн шийдлийг гаргаж хэрэглээнд оруулав.

Apr
13



Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт"-д LED гэрэлтүүлэг шинээр нэмэгдэн оров.

May
20



Орхон аймгийн Баян-Өндөр сумын Цэцэрлэгт хүрээлэн, иргэдийн амарч зугаалах талбайд баг хамт олноороо 300ш мод тарив.

Jun
12



Архангай аймгийн Өндөр-Улаан сумын гэрэлтүүлгийн ажлыг захиалагчийн захиалгын дагуу гэрэлтүүлгийн шийдлийг гарган гүйцэтгэв.

Jun
15



“2023 оны 06 сарын 15, 16-ны өдрүүдэд Хамтдаа Эрдэнэтэд хөгжье-2023 эдийн засгийн форум”-д амжилттай оролцлоо.

Jun 16



БНСУ-аас форумд оролцохоор ирсэн зочид, төлөөлөгч нар манай компаниар зочлон ирж цаашдын хамтын ажиллагааны эхлэлийг тавьснаас гадна хамтын ажиллагааны хүрээнд манай компанийн төлөөлөл 11-р сард БНСУ-д айлчлан уулзалт, хэлэлцээр хийгээд ирлээ

Jun 26



Европын сэргээн босголтын хөгжлийн банкны “EBRD” дэмжлэгтэйгээр Санхүүгийн зөвлөх үйлчилгээ авч үйлдвэрлэлийн өртөг тооцох аргачлалаа шинэчлэн батлуулав. Мөн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны бүртгэлээ процессжуулж, санхүүгийн үйл ажиллагааны журмаа сайжруулан баталж үйл ажиллагаанд нэвтрүүлэн хэвшүүлэхээр ажиллаж байна.

Aug 9



Булган аймгийн Бүрэгхангай сумын гэрэлтүүлэг, захиргаа болон сургууль, цэцэрлэгийн байрны гэрэлтүүлгийн ажлыг харилцагчийн хүсэлд нийцүүлэн захиалгын дагуу, зургийг гарган ажлыг гүйцэтгэв.

Sep 9



Орхон аймгийн Урлагийн Уран эгшиг сургуульд 6ш гадна гэрэлтүүлгийн толгойг хүүхдүүдийн аюулгүй байдалд зориулан хандивлав.

Oct
13



Баян-Өндөр сумын Уртын гол багийн үсгэн хаягийг хийж бэлэглэв.

Oct
20





2023 онд манай залуу инженерүүд Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын Ус өргөх 1, 2-р станцуудын хоорондох хяналт удирдлагын гранит-микро системийг шинэчлэн суурилуулж, тохируулах ажлыг амжилттай хийж гүйцэтгэв. Өөрөөр хэлбэл энэхүү ажил нь Орхон аймгийн айл өрх, албан байгууллагыг цэвэр усаар хангах аюулгүй, найдвартайгаар хангах үйл ажиллагаа юм.

Nov
22



Цахилгаан, эрчим хүчийг хэмнэх зорилгоор нарны сэргээгдэх эрчим хүчийг ашиглан үйлдвэрийн байрны зарим хэсгийн эрчим хүчийг хангах нарны толийг байршуулан ашиглахаар ажиллаж байна.





1.Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлсэн гэрчилгээ.

2.Монгол улс Оюуны Өмчийн газар Барааны тэмдэгтийн гэрчилгээ.





Гадаадын стандартыг хэрэглэгчээр бүртгүүлэн ОХУ- ын Гэрэлтүүлгийн ГОСТ стандартыг үйлдвэрлэлдээ нэвтрүүлэн ажиллаж байна.
2.Эрчим хүчний яамны 0.4-35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар, түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ





Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын “ДАЙМОНД” гишүүнээр элссэн

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн
11,638 ширхэг



1% Шон - 47 ширхэг
1% Тусгай захиалга - 151 ширхэг
5% Таазны гэрэл - 606 ширхэг
6% Гудамжны гэрэл - 727 ширхэг
7% Чийдэн - 824 ширхэг
8 % Прожектор - 950 ширхэг
72% T8, T5 төрлийн гэрэл - 8333 ширхэг



13 **Суурьлуулалт, засвар үйлчилгээний томоохон ажил**



9 **Үсгэн хаяг үйлдвэрлэл**

Статистик мэдээ
2022 оны гүйцэтгэлтэй харьцуулав



Бүтэц бүрэлдэхүүн, хүний нөөцийн тоо мэдээ



2023 онд бид 4 алба, 30 орон тоо бүхий бүтцийг батлан 4 алба, 24 ажилтан албан хаагчтай үйл ажиллагаагаа үргэлжлүүлэв.

Хүйсийн харьцаа



Ажиллаж буй чиглэл



Боловсрол





Ажилласан жил



БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЕЛЭЛТ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Гүйцэтгэл			
		2020	2021	2022	2023
Үйлдвэрлэсэн гэрэлтүүлэг	Сая.төг	956.80	966.90	606.70	702.60
Шууд худалдааны борлуулалт		535.80	512.60	631.90	958.40
МАУ-ний суурилуулалтын ажлын борлуулалт		653.60	403.70	846.10	468.80
Нийт борлуулалтын орлого		**2,146.2**	**1,883.2**	**2,084.70**	**2,129.80**
Борлуулалсан бүтээгдэхүүний өртөг		1312.4	1266.5	1,400.20	946.30
Үйл ажиллагааны зардал		893.4	765	573.90	1,130.20
Цэвэр ашиг		**24.5**	**13.8**	**26.20**	**48.28**
Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо		25,731	21,914	12,443.00	11,638.00
Борлуулсан бүтээгдэхүүний тоо		37,243	21,690		
Үйлдвэрлэлийн хүчин чадал	шир	500-800	500-800	500-800	500-800
Ажил		8	17	20	13
төсөвт төлсөн татвар				277.5	299.1
Үнсэн хөрөнгө				1644	1,607.70



САНХҮҮГИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА

"СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ"ХХК

БАТАЛГААЖУУЛАЛТ, АУДИТ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ, ЗӨВЛӨГӨӨ

Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Оршил төв 501 тоот
Улаанбаатар хот, Монгол улс, 16010, Утас: 11-976-99046494

Огноо:2024-02-27 № 24/02 Улаанбаатар хот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

АНД ЭНЕРГИ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

Бид 2023 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн АНД ЭНЕРГИ ХК компанийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар АНД ЭНЕРГИ ХК компанийн 2023 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулж (эсвэл эдгээрийн талаар үнэн бөгөөд зөв ойлгоц өгч) байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл үүнээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн Аудитад хүлээх Аудиторын хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гаргах нь бидний хариуцлага юм. Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохимжтой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Сонгон авах горимууд нь залилан болон алдааны улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэнээс үүсэх эрсдэлийн үнэлгээ зэргийг багтаасан аудиторуудын мэргэжлийн үнэлэмжээс хамаарна. Тэдгээр эрсдэлийн үнэлгээнүүдийг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс байгууллагын санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг.

Мөн аудитын ажилд хэрэгжүүлж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын таарамж, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцооллуудын бодитой эсэхийг үнэлж үзэх ажил орно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалсан аудиттай холбогдуулан Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулж гаргасан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогч

Гүйцэтгэх захирал Ч.ЭНХЧИМЭГ

Анд энерги ХК

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

